



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 458

Улаанбаатар хот

Гадаадад зээлээр суралцуулах,
тушаалд өөрчлөлт оруулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам", шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Даваадорж овогтой Хуланг Үйлдвэр, худалдааны яамны захиалгаар ХБНГУ-ын Берлин хотын ОТА дээд сургуульд эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Энхболд овогтой Одмөнхийг Гадаад хэргийн яамны захиалгаар ОХУ-ын Дипломатын академид 3 жилийн хугацаагаар, Амгалан овогтой Ишгэрэлийг Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар АНУ-ын Жорж Майсоны их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Бүрэнтогтох овогтой Наранжаргалыг Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар АНУ-ын Калифорнийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар тус тус 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 249 дүгээр тушаалын дагуу Австрали Улсын Викториа их сургуулийн магистрантурт суралцаж буй Маяахүү овогтой Туяагийн суралцах хугацааг 0,5 жилээр сунгасугай.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 334 дүгээр тушаалын Гомбосүрэн овогтой Батнэмэхтэй холбогдолтой хэсгийн "АНУ-ын Вашингтон /Washington/ дахь Strayer дээд сургуулийн англи хэлний эрчимжүүлсэн хөтөлбөр, магистрантурт боловсролын салбарын удирдлага, санхүүгийн тогтолцоо чиглэлээр" гэснийг "Англи Улсын Cocos Лондон коллежийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр" гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 276 дугаар тушаалын Баясгалан овогтой Мөнхцэцэгтэй холбогдолтой хэсгийн "АНУ-ын Колорадогийн их сургуулийн магистрантурт санхүүгийн чиглэлээр" гэснийг "Австрали Улсын Сиднейн их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр" гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 375 дугаар тушаалын Сандаг-Очир овогтой Хишигбаяртай холбогдолтой хэсгийн "АНУ-ын Хойд Вирджинийн их сургуулийн" гэснийг "АНУ-ын Хойд Вирджинийн их сургуулийн Сингапур дахь салбар сургуулийн" гэж тус тус өөрчилсүгэй.

09 1071

4. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-г тус тус даалгасугай.



Н.Болормаа

Н.БОЛОРМАА